



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 1/28

Арвайхээр

Гамшгаас хамгаалах мэргэжлийн
ангийг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.2.3, Монгол улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 75 дугаар тушаал, "Мэргэжлийн ангийн дүрэм шинэчлэн батлах тухай", Монгол Улсын шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаал "Байгууллага аж ахуй нэгжийн гамшгаас хамгаалах, төлөвлөгөө боловсруулах заавар" –ын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бие бүрэлдэхүүн, хээрийн ангийн (эмнэлгийн) бие бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ангийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг гуравдугаар хавсралтаар, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, холбоо мэдээлэл хүргэх журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсын шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан батлуулж, бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг танилцуулан, бэлэн байдлыг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн орлогч /Д.Болормаа/-д үүрэг болгосугай.

3. Штаб, мэргэжлийн ангийг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл; үүрэг гүйцэтгэх багаж хэрэгслээр хангах, гамшгаас хамгаалах ангиллын сургалт явуулахад тус тус шаардагдах төсвийг байгууллагын зардлаас гаргаж зарцуулахыг Хангалт хариуцсан туслах ажилтан (Э.Түмэнжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Гамшгаас хамгаалах хуулийн дагуу байгууллагын "Гамшгийн эрсдэлийн зардал"-д жил бүр байгууллагын төсвийн 0,1 хувийг төсөвлөн зориулалтын дагуу зарцуулахыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр)-т зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/14 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН